



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/65/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2021 он	Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Anhbayard@audit.gov.mn">Anhbayard@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enhtsoodolj@audit.gov.mn">Enhtsoodolj@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Sodnomp@audit.gov.mn">Sodnomp@audit.gov.mn</a>  Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Suvdaaa@audit.gov.mn">Suvdaaa@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>УСНББОУС</b>	<b>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</b>
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	18
4. Менежментийн захидал .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.01.25 № 53  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ Т

БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА С.ЛУВСАНЦООДОЛ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчил нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд 20340000 төгрөгийн нөөцийн материал бэлтгэж 11693900 төгрөгийн зарцуулалт хийгдсэн ч орлого, зарлагын анхан шатны баримтыг батлагдсан маягаар тайлагнаагүй байна. Мөн нөөцийн бараа материал зарж борлуулсан бэлэн мөнгөний тайлан байхгүй, тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д

006000112

"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.12, 8.1 дэх заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,198,101.98</b>	<b>42,996,353.38</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	14,914,500.00	8,556,375.73
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	11,947.73
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	14,914,500.00	8,544,428.00
3351	Байгууллагаас авах авлага	11,346,700.00	2,798,130.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,567,800.00	5,746,298.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	50,929,603.98	16,439,977.65
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,758,058.20	1,758,058.20
35110	Тусгай зориулалттай материал	1,758,058.20	1,758,058.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	45,111,545.78	10,621,919.45
35410	Бичиг хэргийн материал	649,580.00	493,180.00
35420	Аж ахуйн материал	8,409,327.45	9,600,739.45
35430	Сэлбэг хэрэгсэл	-	528,000.00
35470	Бусад хангамжийн материал	36,052,638.33	-
35600	Мал амьтад	4,060,000.00	4,060,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9,353,998.00	18,000,000.00
36300	Тэжээлийн нөөц	9,353,998.00	18,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,163,601,505.36</b>	<b>1,192,694,203.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,163,601,505.36	1,192,694,203.60
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,163,294,005.32	1,192,427,953.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,774,777.83	1,049,997,186.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(170,643,072.61)	(205,501,698.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,317,662.00	234,870,132.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(163,152,128.62)	(166,990,059.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	85,514,192.00	100,096,822.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,678,604.79)	(35,395,982.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,005,108.33	44,518,277.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,616,084.33)	(10,599,562.93)
39209	Зам, гүүрийн байгууламж	133,304,200.00	133,304,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(32,712,404.93)	(38,274,359.57)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,176,300.00	20,176,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,160,000.00	74,262,638.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,155,939.56)	(8,035,939.59)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	307,500.04	266,250.07
39301	Програм хангамж	1,770,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,462,499.96)	(283,749.93)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,238,799,607.34</b>	<b>1,235,690,556.98</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>3,300,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	3,300,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	3,300,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	3,300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,300,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,238,799,607.34</b>	<b>1,232,390,556.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,238,799,607.34	1,232,390,556.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,751,072.17	612,751,072.17
51101	Өмч: - төрийн	612,751,072.17	612,751,072.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	137,840,008.65	134,448,550.09
51210	Өмнөх үеийн үр дүн	137,840,008.65	140,857,600.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	(6,409,050.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,208,526.52	485,190,934.72

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,238,799,607.34</b>	<b>1,235,690,556.98</b>
---	--	-------------------------	-------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>569,935,717.00</b>	<b>549,896,421.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,524,400.00</b>	<b>93,200,173.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,524,400.00	93,200,173.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,524,400.00	1,186,949.00
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		
1	санхүүжих	650,000.00	1,186,949.00
120004	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,874,400.00	-
5			
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		91,893,224.57
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө		120,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>549,411,317.00</b>	<b>456,696,248.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	84,310,800.00	344,333,451.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,310,800.00	344,333,451.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	133,118,117.00	112,362,797.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,500,000.00	104,419,772.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,607,397.00	4,839,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,010,720.00	3,103,640.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	331,982,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	316,735,600.00	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	15,246,800.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>534,144,840.28</b>	<b>540,803,972.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>534,144,840.28</b>	<b>540,803,972.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	528,657,859.28	520,028,363.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,882,836.00	225,264,997.18
210101	Үндсэн цалин	199,882,836.00	225,264,997.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,596,791.00	28,181,135.18
210201	Тэтгэврийн даатгал	16,985,898.00	19,705,122.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,998,339.00	2,301,870.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,598,672.00	1,825,783.33
210204	Ажилгүйдлийн даатгал	364,897.00	395,301.50
210205	Эрүүл мэндийн даатгал	3,648,985.00	3,953,057.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,404,520.00	29,913,488.00
210301	Гэрэл, цахилгаан	1,417,462.00	3,926,388.00
210302	Түлш, халаалт	25,987,058.00	25,987,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,126,030.00	29,737,751.00
210401	Бичиг хэрэг	5,418,330.00	2,757,890.00
210402	Тээвэр, шатахуун	22,216,900.00	21,440,410.00

Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,346,800.00	1,346,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,000.00	653,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	134,000.00
210408	Бараа материал акалсны зардал	-	3,105,201.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,320,200.00</b>	<b>4,590,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	9,090,000.00	4,440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	930,200.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,935,700.00</b>	<b>35,453,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.00	396,000.00
210604	Урсгал засвар	6,185,700.00	35,057,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>32,089,500.00</b>	<b>20,398,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	32,089,500.00	20,398,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>741,000.00</b>	<b>3,371,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	741,000.00	3,371,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>197,561,282.28</b>	<b>143,117,692.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,416,139.00	75,802,427.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	20,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,145,143.28	67,295,265.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,486,981.00</b>	<b>20,775,608.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,860,000.00</b>	<b>17,697,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	15,497,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,860,000.00	2,200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>3,042,908.91</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,042,908.91
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,626,981.00</b>	<b>35,200.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,626,981.00	35,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>35,790,876.72</b>	<b>9,092,449.27</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,715,860.00</b>	<b>15,501,499.63</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,948,861.30
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,715,860.00	13,552,638.33
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(7,715,860.00)</b>	<b>(15,501,499.63)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>28,075,016.72</b>	<b>(6,409,050.36)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>461,850,417.00</b>	<b>476,405,397.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>650,000.00</b>	<b>1,186,949.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>650,000.00</b>	<b>1,186,949.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>650,000.00</b>	<b>1,186,949.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000.00	1,186,949.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>461,200,417.00</b>	<b>475,218,448.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>344,333,451.00</b>

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		344,333,451.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	144,464,817.00	130,884,997.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,500,000.00	104,419,772.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,607,397.00	4,839,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,357,420.00	21,625,840.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	316,735,600.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	316,735,600.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>448,020,417.00</b>	<b>469,961,797.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>448,020,417.00</b>	<b>469,961,797.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>431,186,736.00</b>	<b>446,388,058.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,882,836.00	225,264,996.91
210101	Үндсэн цалин	199,882,836.00	225,264,996.91
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,596,791.00	28,193,083.18
210201	Тэтгэврийн даатгал	16,985,898.00	19,717,070.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,998,339.00	2,301,870.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,598,672.00	1,825,783.33
210204	Ажилгүйдлийн даатгал	364,897.00	395,301.50
210205	Эрүүл мэндийн даатгал	3,648,985.00	3,953,057.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,404,520.00	29,913,488.00
210301	Гэрэл, цахилгаан	1,417,462.00	3,926,388.00
210302	Түлш, халаалт	25,987,058.00	25,987,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,000,370.00	26,187,050.00
210401	Бичиг хэрэг	4,340,670.00	3,369,490.00
210402	Тээвэр, шатахуун	22,216,900.00	21,170,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,346,800.00	1,346,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	10,190,000.00	4,590,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	9,090,000.00	4,440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,471,700.00	39,675,013.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	704,513.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	840,000.00	700,000.00
210604	Урсгал засвар	5,631,700.00	38,270,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	32,089,500.00	20,398,800.00
210702	Дотоод албан томилолт	32,089,500.00	20,398,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,341,000.00	4,141,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,341,000.00	4,141,150.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	101,210,019.00	68,024,477.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,210,019.00	68,024,477.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,833,681.00</b>	<b>23,573,738.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,860,000.00	17,697,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	15,497,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,860,000.00	2,200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	3,042,908.91

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,042,908.91
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,973,681.00	2,833,330.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,973,681.00	2,833,330.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>13,830,000.00</b>	<b>6,443,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,830,000.00</b>	<b>6,443,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,830,000.00</b>	<b>6,443,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	13,830,000.00	6,443,600.00
222001	Тоног төхөөрөмж	13,610,000.00	6,443,600.00
223001	Бусад хөрөнгө	220,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(13,830,000.00)</b>	<b>(6,443,600.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	(0.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	612,751,072.17	488,208,526.52	137,840,008.65	-	1,238,799,607.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,017,591.80	-	3,017,591.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	3,017,591.80	-	3,017,591.80

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(3,017,591.80)	-	(3,017,591.80)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,409,050.36)	(6,409,050.36)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>612,751,072.17</b>	<b>485,190,934.72</b>	<b>134,448,550.09</b>	<b>-</b>
					<b>1,232,390,556.98</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	363915100.00	342477491.09
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	363915100.00	337873891.09
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	345557600.00	320176391.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	236081600.00	224747046.91
210101	Үндсэн цалин	236081600.00	224747046.91
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29510200.00	28129398.18
210201	Тэтгэврийн даатгал	20067000.00	19653385.64
210202	Тэтгэмжийн даатгал	2360800.00	2301870.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1888600.00	1825783.33
210204	Ажилгүйдлийн даатгал	472200.00	395301.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4721600.00	3953057.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30243500.00	29913488.00
210301	Гэрэл, цахилгаан	4256400.00	3926388.00
210302	Түлш, халаалт	25987100.00	25987100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17534100.00	17247200.00
210401	Бичиг хэрэг	3326300.00	3039490.00
210402	Тээвэр, шатахуун	12901000.00	12900910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,666,600.00	3,975,013.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,666,600.00	704,513.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,270,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,378,600.00	3,624,000.00
210702	Дотоод албан томилолт	5,378,600.00	3,624,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,300,000.00	769,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,300,000.00	769,650.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,843,000.00	11,770,595.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,843,000.00	11,770,595.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,357,500.00	17,697,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,357,500.00	17,697,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,497,500.00	15,497,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,860,000.00	2,200,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,603,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,603,600.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,603,600.00
223001	Бусад хөрөнгө	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	365,529,400.00	345,520,400.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	364,229,400.00	344,333,451.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	364,229,400.00	344,333,451.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
132001	Орон нутгийн төсвөөс	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,300,000.00	1,186,949.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	1,186,949.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>128,051,667.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>126,211,667.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	126,211,667.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	517,950.00
210101	Үндсэн цалин	-	517,950.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	63,685.00
210201	Тэтгэврийн даатгал	-	63,685.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	8,939,850.00

210401	Бичиг хэрэг	-	330,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	8,269,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	40,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>4,590,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	150,000.00
210502	Хоол, хүнс	-	4,440,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>35,700,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	700,000.00
210604	Урсгал засвар	-	35,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>16,774,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	16,774,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>3,371,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,371,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>56,253,882.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	56,253,882.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>2,833,330.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,833,330.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,840,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,840,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,840,000.00
<b>П</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>130,884,997.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>130,884,997.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	104,419,772.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,839,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,625,840.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга С.Лувсанцоодол танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-оос 2021 оны 02 дугаар сарын 25-ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймгийн Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 25-нд-ны өдрийн 03/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Засгийн газрын бодлого шийдвэр, “Хөгжлийн хөтөч” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, “Нутагтаа Сайхан амьдаръя” сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, гүйцэтгэлийн төлөвлөгөө нь заалт бүрээр хэрэгжсэн, төсвийн болон шилэн дансны тухай хууль, ОУНББ-ын стандартын дагуу төсөв санхүүг оновчтой зарцуулагдаж, Иргэн төвтэй төрийн үйлчилгээг иргэн, айл өрхөд хүрч үйлчилсэн, чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 стандарт болон байгууллагын удирдлагын цогц системийг бүрэн нэвтрүүлсэн, ахмадаа асарч, залуучуудын хөгжлийг дэмжсэн, ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай, захирах, захирагдах зарчмыг баримталсан, зөв боловсон харьцаатай угтах үйлчилгээ нь хэвшил болсон, ажлын үзүүлэлтээрээ аймагтаа тэргүүлэх байр эзэлсэн, бүтээн байгуулалтын жилийн ажлыг үр дүнтэй зохион байгуулсан, байгууллагын соёл, багаар ажиллах чадвар төгөлдөржсөн тэргүүний хамт олон болох эрхэм зорилгыг 2020 онд дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол
- Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны А/106 дугаар
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол

- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай Засгийн газрын 163 дугаар тогтоол,
- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайхан сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад Санхүү хяналт аудитын газар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “11126.1 мянган төгрөгийн” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 213384.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4267.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3109.1 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	14914.5	8556.4	-6358.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	60283.5	34439.9	-25843.6
Үндсэн хөрөнгө	1163601.5	1192694.2	29092.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1238799.6</b>	<b>1235690.6</b>	<b>-3109.1</b>
Өр төлбөр	0	3300.0	3300.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1238799.6	1232930.6	-6409.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1238799.6</b>	<b>1235690.6</b>	<b>-3109.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 14914.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8556.4 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34439.9 мянган төгрөг болж 25843.6 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалаас 13552.6 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэн, 3105.2 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалжээ.

Тайлант хугацааны эцсийн үлдэгдлээр 18000.0 мянган төгрөгийн нөөцийн материал байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9 дахин их үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1192694.2 мянган төгрөг болж 29092.7 мянган төгрөгөөр өссөн нь 13552.6 мянган төгрөгийн бараа материалын данснаас шилжин ирсэн, ОНХС болон бусад эх үүсвэрээс нийт 73269.3 мянган төгрөгийн хөрөнгө, дахин үнэлсэн 5071.3 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 6443.6 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дахин үнэлсэн 22849.6 мянган төгрөг, акталсан 20733.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3300.0 мянган төгрөг болж 3300.0 мянган төгрөгөөр өссөн нөөцийн материал бэлтгэхтэй холбоотой үүсжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1229230.6 мянган төгрөг болж 9569.1 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал, үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20039.3 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь төрийн үйлчилгээний албан хаагчдад удаан жилийн нэмэгдэл олгох, тайланд онд элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин ашиглах болсонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 6659.1 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 3017.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь дахин үнэлэгдсэн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388229.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 388229.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 34516.7 мянган төгрөгөөр бууруулж ЗДТГ-ыг 265280.7, багийг 88432.0 нийт 353712.7 мянган төгрөгөөр баталсан

байна. Тайлант хугацаанд нийт 1 удаагийн тодотгол хийгдсэн бөгөөд 10202.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 363915.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэн ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 363915.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 364229.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 1300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 344333.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1186.9 мянган төгрөг, нийт 345520.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 342477.5 мянган төгрөгийг зарцуулж 3042.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345520.4 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 11334.5, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1380.8, байр ашиглалтын зардлыг 330.0, хангамжийн материалын зардал 286.9, эд хогшил урсгал засварын зардал 8691.6, томилолтын зардал 1754.6, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1530.4, бусад урсгал шилжүүлэг 660.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үндсэн арга хэмжээ 16892.4 мянган төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагаа арга хэмжээ 2374.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 104419.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 4839.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21625.8 мянга, нийт 130884.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 517.9, ажил олгогчоос НДШ-д 63.7, хангамж бараа материалын зардалд 8939.8, норматив зардалд 4590.0, эд хөгшиг урсгал засварт 37540.0, томилолт зочны зардалд 16774.8, бусаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 3371.5, бараа үйлчилгээний бусад зардалд 56253.9 нийт 128051.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2833.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, таван сая төгрөгөөс дээш дүн бүхий 30 удаагийн 350300.0 мянган төгрөгийн орлого, 7 удаагийн 58600.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2298.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн актын хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2298.8	2	2298.8	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	2	2298.8	2	2298.8	0	0	0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23923.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11693.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 12229.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулсан алдаа байхгүй болно

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 11693.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэнд 1 шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд 20340.0 мянган төгрөгийн нөөцийн материал бэлтгэж 11693.9 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн ч орлого, зарлагын анхан шатны баримтыг батлагдсан маягтаар тайлагнаагүй байна. Мөн нөөцийн бараа материал зарж борлуулсан бэлэн мөнгөний тайлан байхгүй, тухай бүрт орлогоор хүлээн зөвшөөрөөгүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.12, 8.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12229.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Нөөцийн бараа материалын бэлдэх, нөөц үүсгэх, зарцуулалт болон аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг дахин хянах нь зүйтэй гэж үзлээ

#### **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1. Орлогын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Орлого давхар төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### *2. Цалингийн данстай холбоотой асуудал*

2.1.Илрүүлэлт: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг батлуулахдаа эдийн засгийн ангилал бүрээр батлуулахгүй үндсэн цалин гэсэн нэг дүнгээр батлуулсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал"-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл: батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт гарахгүй байх, Сангийн сайдын тушаал биелэгдэхгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал"-ыг бүрэн хэрэгжүүлж ангиллын дагуу төсвийг батлуулж зарцуулах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### *3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд 8556.4 мянган төгрөгийн авлага, 3300.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 39 дүгээр зүйлийн 39.4.2-т "өр, авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, найдваргүй авлага үүсэх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 39 дүгээр зүйлийн 39.4.2-т "өр, авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### *4.Зардлын данстай холбоотой асуудал*

4.1. Илрүүлэлт: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Жолоочийн тооцооны хуудсыг хэрэглээгүй байна.

4.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, дотоод хяналт сулрах

4.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдан НХМаягт ТМ-4 маягтын дагуу хөтлөлтийг бүрэн хийж байх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### *5.Зардлын данстай холбоотой асуудал*

5.1. Илрүүлэлт: 2019 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байж олгосон нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "тасралтгүй байх", 5.1.3 дахь "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 дэх "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь "бүх өр төлбөр" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

5.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, дотоод хяналт сулрах

5.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасны дагуу тооцооллыг тухай бүр хийх, төсвийг зохистой удирдах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### *6.Зардлын данстай холбоотой асуудал*

6.1. Илрүүлэлт: ЗД-ын нөөц хөрөнгөөр олж бэлтгэсэн материаллаг хөрөнгийг шууд зарлагадан орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн "6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", ЗДТГ-ын даргын 2010 онд баталсан НБББББ-ийн 3-т "Анхан шатны баримт ба АШБ-аар бараа, үйлчилгээ олгох" тус тус зөрчсөн байна.

6.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, дотоод хяналт сулрах

6.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах" журам, НБББББ-т тусгасны дагуу холбогдох дансанд орлогоор хүлээн зөвшөөрч холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### *7.Зардлын данстай холбоотой асуудал*

7.1. Илрүүлэлт: НӨАТ тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ", 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 9437.8 мянган төгрөгийн төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн байна.

7.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, дотоод хяналт сулрах

7.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### *8.Шилэн данстай холбоотой асуудал*

Сайхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг огт мэдээлээгүй, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 30 удаагийн 350.3 сая төгрөгийн орлого, 7 удаагийн 58.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, тушаал шийдвэрийн мэдээлэл оруулаагүй байна.

8.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, дотоод хяналт сулрах

8.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.2.4, 6.4.5, 6.4.7, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13, 2.2.2.3, 2.2.3.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

8.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.АНХБАЯР  
Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР



А.СУВДАА